| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,000,000.00 | 1,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,343,000.00 | 33,341,950.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,384,000.00 | 5,364,628.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,384,000.00 | 5,364,628.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 666,852,127.00 | 45,947,928.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 665,651,327.00 | 44,815,081.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 238,600.00 | 238,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 224,200.00 | 222,247.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 650,000.00 | 650,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 97,693,195.00 | 41,155,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,693,195.00 | 39,185,360.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.00 | 1,969,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80,037,500.00 | 68,188,832.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,037,500.00 | 68,188,832.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,759,300.00 | 28,390,632.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,798,200.00 | 28,798,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,480,000.00 | 6,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **98,830,000.00** | **126,478,816.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 98,830,000.00 | 126,478,816.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 28,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 98,830,000.00 | 97,978,816.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 988,064,345.38 | 988,064,345.38 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 967,857,800.00 | 967,857,800.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 967,857,800.00 | 967,857,800.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 20,206,545.38 | 20,206,545.38 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,206,545.38 | 20,206,545.38 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **300,000.00** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 42.00 | 42.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 9.00 | 9.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 6.00 | 6.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **42.00** | **42.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12.00 | 12.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16.00 | 16.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 6.00 | 6.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 8.00 | 8.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **676,170,837.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **587,376,862.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 583,896,862.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,757,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,697,440.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 552,816,227.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 552,816,227.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,323,195.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,323,195.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,480,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,480,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,480,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **88,793,975.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 88,793,975.00 |
| 220001 | Барилга байгууламж | 63,793,975.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 25,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 681,030,462.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 681,030,462.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 681,030,462.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Тамгын газрын эрхэм зорилго нь Засаг даргын бүрэн эрхээ тасралтгүй, хэвийн, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж,иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэйгээр төрийн үйлчилгээг хүргэхэд оршино” зорилгын хүрээнд ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль Төрийн албаны тухай хууль Шилэн дансны хууль Төрийн болон орон нутгийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 226,027.4 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 300.0 | 300.0 |
| Авлага | - | 3,000.0 | 3,000.0 |
| Бараа материал | 37,269.9 | 36,364.0 | (905.9) |
| Үндсэн хөрөнгө | 3,225,982.4 | 3,457,169.4 | 231,187.0 |
| **Нийт хөрөнгө** | **3,270,806.1** | **3,496,833.4** | **226,027.4** |
| Өр төлбөр | 4,470.8 | 4,470.8 | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,266,335.2 | 3,492,362.6 | 226,027.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,270,806.1** | **3,496,833.4** | **226,027.4** |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тус байгууллага 117,761.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 300,000.00 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 3,150.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайланд хугацаанд 184,321.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Аймгийн ИТХ-ын XI/08, XII/17 тоот тогтоолоор “Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төв 107.3 сая төгрөгийн барилгын өргөтгөлийг сумын ЗДТГ-т хөрөнгөөр бүртгэхээр шийдвэр гарсан ч өрхийн эмнэлгээс шүүхэд нэхэмжлэх гарган Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 158/ШШ2023/0004 дугаар захирамжаар тус хөрөнгийг “Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төвд шилжүүлэх эвлэрлийн гэрээ байгуулжээ.

Мөн аймгийн ИТХ-ын XII/17 тоот тогтоолоор Эмийн цэцэглэн” өрхийн эрүүл мэндийн төвийн 6337 БУА улсын дугаартай прусс-41 автомашиныг Булган сумын ЗДТГ-т орлого авах шийдвэр гарсан ч ашиглагч байгууллага болох эрүүл мэндийн төвд бүртгэн бүртгэл тайланд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 960,965.5 мянган төгрөг буюу ЗДТГ 773,990.9 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө 30,000.0 мянган төгрөг, багийн Засаг дарга 179,912.2 мянган төгрөгийг зарцуулахаар, үндсэн үйл ажиллагааны орлогоос 22,937.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 135,598.5 мянган төгрөгөөр бууруулж, 848,304.6 /ЗДТГ 640,392.6, Багийн ЗД 177,912.2, ЗД-ын нөөц 30,000.0/ мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 07-ны XI хуралдааны 19 дүгээр тогтоолоор 1,123,537.8 /ЗДТГ 727,133.1, Багийн ЗД 274,224.7, ЗД-ын нөөц 30,000.0/ мянган төгрөг болгон 275,233.2 мянган төгрөг нэмж тодотгосон байна.,

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 967,857.8 мянган төгрөг, үйл ажиллагаанаас 20,206.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 681,030.5 мянган төгрөг нийт 1,807,019.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,804,774.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,244.9 мянган төгрөгөөр дутуу байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 70106 | | ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 1,807,019.76 | 1,804,774.81 | 2,244.95 | 99.9% |
| 1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 701,710.30 | 701,827.85 | (117.55) | 100.0% |
| 2 | 80106 | Баг, хорооны ҮАЗардал | 165,306.20 | 165,306.20 | - | 100.0% |
| 3 | 80112 | Нийтлэг үйлчилгээ | 86,523.10 | 86,523.10 | - | 100.0% |
| 4 | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 2,362.50 | - | 2,362.50 | 0.0% |
| 5 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 32,856.90 | 32,856.90 | - | 100.0% |
| 6 | 80815 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг | 36,759.30 | 36,759.30 | - | 100.0% |
| 7 | 80819 | Иргэдэд хүртээх хувь хишиг | 589,099.52 | 589,099.52 | - | 100.0% |
| 8 | 80918 | Бусад | 98,830.00 | 98,830.00 | - | 100.0% |
| 9 | 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 30,000.00 | 30,000.00 | - | 100.0% |
| 10 | 81517 | Статистикийн бусад тооллого, с | 2,571.94 | 2,571.94 | - | 100.0% |
| 11 | 82207 | Хотын доторх ногоон байгууламж | 50,000.00 | 50,000.00 | - | 100.0% |
| 12 | 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдол | 1,500.00 | 1,500.00 | - | 100.0% |
| 13 | 82801 | Улсын их баяр наадам | 5,000.00 | 5,000.00 | - | 100.0% |
| 14 | 83112 | Хөтөлбөр төслийн дотоод урсгал | 4,500.00 | 4,500.00 | - | 100.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 681,030.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 676,170.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/64 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,123,537.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,853.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49 удаагийн 1,284,246.4 мянган төгрөгийн орлого, 9 удаагийн 839,448.3 мянган төгрөгийн зарлага, худалдан авалтын 815,900.1 мянган төгрөгийн гүйлгээ, 31 удаагийн 48,356.7 мянган төгрөгийн тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хувийн авто машин хэрэглэн 1,145.8 мянган төгрөгийг зарцуулсан нь Хэмнэлтийн тухай хуулийн 6.3-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.
*Шийдвэрлэсэн нь*:
Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зайлшгүй хувийн автомашин ашиглах тохиолдолд гэрээ байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/836 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 1,170.0 | 1 | 1,170.0 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **1,170.0** | **1** | **1,170.0** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд анхаарах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,027.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулаа.

Үүнд: бэлэн мөнгөний орлого, зарлагын тайланг алдаатай илэрхийлсэн, үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн.

Аудитаар нийт 14,834.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 1,394.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 13,440.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Анхан шатны баримтгүй 537.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, тохиолдсон ба иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Үр дүнгийн урамшууллыг олгохдоо 319.1 төгрөгийг илүү тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй гурван албан хаагчдад 538.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2, 2.7, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 3.11-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

1.Бэлэн мөнгөөр 5,741.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан гэх боловч нярав орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтын 3.8, 7.5-д заасныг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тамгын даргын 2022 оны 12 дугаар сарын 12-ны А/28 тоот тушаалаар комисс томилон тооллогыг хийсэн ч тооллого хийсэн өдрөөс хойших бараа материалын хөдөлгөөнийг тулгахад 3,460.3 мянган төгрөгийн зөрүүтэй нь тооллогыг үнэн зөв хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

3."Булган хотын хавар" урлагийн наадамд идэвхтэй оролцсон албан хаагчдад Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний Б/46 тоот захирамжаар, Тамгын даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний Б/48 тоот тушаалаар Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг үндэслэн 4,238.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.2, 2.1-т заасныг зөрчсөн, тохиолдсон байх болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үгнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хаан банкны 5270437477 дугаар дансны бэлэн мөнгөний орлого зарлагын тайланг үнэн зөв гаргаагүй. | 1 | 7,560.00 | 0 | 0 | 1 | 7,560.00 | 1 | 1,064.00 | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн | 1 | 467.20 | | | 1 | 467.20 | 1 | 467.20 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 2 | 8,027.20 | 0 | 0 | 2 | 8,027.20 | 2 | 8,027.20 | 0 | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үгнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бэлэн мөнгөний тайланд анхан шатны баримтгүй зарцуулсан | 1 | 537.00 | 1 | 537.00 | | | | | | | | |
| Бэлэн мөнгөөр бараа материал худалдан авсан гэх боловч нярав орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн | 1 | 5,741.70 | | | 1 | 5,741.70 | | | | | | |
| 2022 оны 12 дугаар сарын 12-ны А/28 тоот тушаалаар тооллогын комисс томилон тооллогыг хийсэн | 1 | 3,460.28 | | | 1 | 3,460.28 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ч тооллого хийсэн өдрөөс хойших хөдөлгөөнийг тулгахад зөрүүтэй | | | | | | | | | | | | |
| Үр дүнгийн урамшууллыг олгохдоо илүү тооцож олгосон, мөн сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон | 1 | 857.17 | 1 | 857.17 | | | | | | | | |
| Үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаал, шийдвэрийг алдаатай боловсруулж олгосон | 1 | 4,238.54 | | | 1 | 4,238.54 | | | | | | |
| Дүн | 5 | 14,834.69 | 2 | 1,394.17 | 3 | 13,440.52 | 0 | - | 0 | - | 0 | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн системд шийдвэр болон тендерийн мэдээллийг байршуулаагүй | 1 | 2,987,951.49 | | | 1 | 2,987,951.49 | | |
| Дүн | 1 | 2,987,951.49 | 0 | 0 | 1 | 2,987,951.49 | 0 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Албан хэрэгцээнд хувийн авто машин ашигласан | 1 | 1,145.81 | | | 1 | 1,145.81 | | |
| Дүн | 1 | 1,145.81 | 0 | 0 | 1 | 1,145.81 | 0 | 0 |
| Нийт дүн | 2 | 2,989,097.30 | 0 | 0 | 2 | 2,989,097.30 | 0 | 0 |

**-oOo-**